



Funded by the
European Union



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага



International
Labour
Organization



ПРОФАЙЛИНГ ХИЙХ ЗӨВЛӨХИЙН УР ЧАДВАР

“Монгол улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл



АМЧБО ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ МЭРГЭЖИЛ БОЛОХ НЬ

АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ (CAREER PROFESSIONALS)

Үндсэн ажил мэргэжлийнхээ хүрээнд боловсрол, сургалтын зөвлөгөө өгөх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох байдлаар хүний нөөцийн хөгжлийг дэмжиж ажилладаг ажилтан бөгөөд үйлчлүүлэгчдэд тулгарсан ярвигтай асуудал, шилжилтийн үеийг даван туулах зэрэг бэрхшээл тулгамдсан үед мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажилладаг.



АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ (CAREER ADVISORS)

Үйлчлүүлэгчдэд босго шаардлага багатай ажил мэргэжлийн дагалдсан дэмжлэг туслалцаа үзүүлдэг ба аливаа асуудал тулгарсан үед хамгийн түрүүнд “хүлээн авч, харилцах хүн” нь болж ажилладаг.

АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖААНЫ МЭРГЭЖИЛТЭН (CAREER SPECIALISTS)

Европ дахь ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний инновацийн сүлжээний нэг буюу хэд, хэдэн ажил мэргэжил (ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх, мэдээлэл оношлогооны эксперт, карьерийн дагалдах ур чадвар хөгжүүлэх сургагч багш, нийгмийн системийг хөгжүүлэгч, зөвлөх үйлчилгээний менежер)-ээр давхар мэргэшсэн байх шаардлагатай.



Ажил мэргэжлийн зөвлөх гэж хэн бээ?



АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХИЙН ЧИГ ҮҮРЭГ

МЭДЭЭЛЛИЙН МЕНЕЖМЕНТ 27%

Сургалт, боловсрол
Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт
Хөдөлмөрийн зах зээл
Зөвлөх болон мэдээллээр хангах үйлчилгээ

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИДТЭЙ БҮЛГЭЭР АЖИЛЛАХ 12%

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт
Бүлгийн зөвлөгөө өгөх
Өөртөө туслах бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх

МЕНЕЖМЕНТ 10%

Үйлчилгээ/ хөтөлбөрийн төлөвлөлт, үнэлгээ
Гадагш чиглэсэн харилцаа

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧТЭЙ ГАНЦААРЧЛАН АЖИЛЛАХ 21%

Үнэлгээний тест (Aptitude үнэлгээ)
Мэдээлэл өгөх
Ганцаарчилсан зөвлөгөө өгөх

АЖЛЫН БАЙРАНД ЗУУЧЛАХ 30%

Ажилд зуучилсны дараах зөвлөгөө
Хамтран ажиллах, харилцаагаа өргөтгөх,
чанарын шаардлага хангасан тодорхойлолт



АМЧБО ЗӨВЛӨХИЙН ОУ ТӨВШИНД ТОДОРХОЙЛОГДСОН ЧАДАМЖ

Ёс зүйт зан төлөв

Үнэлгээ

Боловсрол сургалтын
чиглүүлэг өгөх

Ажил мэргэжлийн
хөгжил

Хөтөлбөрийн
/үйлчилгээний
менежмент



Зөвлөгөө өгөх

Мэдээллийн менежмент

Зөвлөлдөх зохицуулах

Судалгаа, үнэлгээ

Олон нийтийг
чадавхжуулах

Ажилд зуучлах



ЗӨВЛӨХҮҮДИЙН ЧАДАМЖУУД



ХӨНДЛӨН (TRANSVERSAL) ЧАДАМЖУУД

- Үйлчлүүлэгчид төвлөрөх (Client Orientation)
- Чиг баримжаа олгох санал ил тод байх
- Мэргэжлийн хандлага, ёс зүйтэй зан байдал
- Чанар хөгжүүлэх үйл явцыг хамтран бүтээх



БАЙГУУЛЛАГАТАЙ ХОЛБООТОЙ ЧАДАМЖУУД

- Байгууллагын хэтийн зорилгыг боловсруулж, хэрэгжүүлэх
- Байгууллагын албан бүтэц, үйл явцуудыг боловсруулж, төгөлдөржүүлэх
- Байгууллагын соёлыг хамтран бүтээж хэрэгжүүлэх
- Нөөцийн ашиглалтыг тогтвортой болон үр ашигтай байлгах явдлыг баталгаажуулах
- Мэргэжлийн болон салбар дамнасан орчинд хамтран ажиллах



ҮЙЛ ЯВЦТАЙ ХАМААРАЛТАЙ ЧАДАМЖУУД

- Тогтвортой ажлын нөхцөл болон баталгаатай орчин нөхцөл бүрдүүлэх
- Ажил хэргийн эрүүл холбоо болон сэтгэл санааны аюулгүй байдал бий болгох
- Үйлчлүүлэгчийн сэтгэл зовнилыг арилгаж, чиг баримжаа олгох гэрээ байгуулах
- Нөхцөл байдал болон зорилгуудыг тодорхойлох
- Үйлчлүүлэгчийн дотоод болон гадаад нөөц бололцоог тодорхойлж, ашиглах
- Асуудал бэрхшээлийг шийдвэрлэх, арга хэмжээ авах боломжуудыг боловсруулах



НИЙГЭМТЭЙ ХОЛБООТОЙ ЧАДАМЖУУД

- Нийгмийн орчин нөхцөлийг харгалзах
- Нийгмийн зорилгуудыг харгалзах





ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮЙЛ ЯВЦ, ҮЕ ШАТ

Та зөвлөгөө өгдөг үү? эсвэл Мэдээлэл өгдөг үү?

- **Мэргэжлийн түвшин** – мэргэжлийн сэтгэл зүйч, сэтгэл мэдрэлийн эмч
- **Анхан шат /гал унтраах/** - нийгмийн, халамжийн ажилтнууд
- **Сайн дурын ажилтнууд** – олон нийт, хүүхэдтэй ажилладаг хүмүүс
- **Албан бус зөвлөгчид** – сайн дураараа орчныхоо хүмүүсд сэтгэл санааны дэмжлэг үзүүлдэг хүмүүс



ЗӨВЛӨГӨӨГ ХЭН ӨГДӨГ ВЭ?





ЗӨВЛӨХИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

НУУЦЫГ ЧАНДЛАН ХАДГАЛАХ

ХАМТРАН АЖИЛЛАХ ЗАМААР
ШИЙДВЭР ГАРГАХ

ХУВИЙН ХАРЬЦАА ТОГТОХООС
ЗАЙЛСХИЙХ

ШУУД ЗӨВЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭ ХҮНДЭТГЭЛ
ҮЗҮҮЛЭН ХАНДАЖ, ХАРЬЦАХ ЗАРЧИМ



ЗӨВЛӨХИЙН БЭЛТГЭЛ



Онолын бэлтгэл

Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын тухай сургалтад хамрагдсан байдал

Практик бэлтгэл

Зөвлөгөөний тодорхой арга техник ашигласан эсэх, зөвлөгчийн туршлага г.м

Хувийн бэлтгэл


Үйлчлүүлэгчийн асуудлыг сэтгэл зүйн үүднээс бодох, үнэлэмж, хандлага г.м



ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮЙЛ ЯВЦ



ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦ



1 АЛХАМ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БЭРХШЭЭЛИЙГ ТАНИУЛАХ

1 шат: Хамтран ажиллах харилцаа тогтоох

2 шат: хөдөлмөр эрхлэлтийн хариуцлага тулгарах бэрхшээлийг дурьдах

3 шат: тугарч буй бэрхшээлийг нарийвчлан тогтоох

4 шат: Ярилцлагын зорилгыг тодорхойлох



2 АЛХАМ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БЭРХШЭЭЛИЙГ ОЙЛГУУЛАХ

5 шат: Ой тогтоолт, гадны нөлөөлөл, зан байдал, харилцан хамаарлын бэрхшээлийг байх талаар үйлгуулах

6 шат: Хөдөлмөр эрхлэлтийн бэрхшээлтэй холбоотой хувийн болон орчин тойрны нөөц ба хязгаарлалтыг тодорхой болгох

7 шат: Хөдөлмөр эрхлэлтийн бэрхшээлтэй холбоотой үйлчлүүлэгчийн үнэлгээг тодорхойлох




3 АЛХАМ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

8 шат: Зорилгыг тогтоож
сонголтыг бий болгох

9 шат: Үйл ажиллагааны
тэргүүлэх чиглэлийг тогтоох

10 шат: Үйл ажиллагааны
төлөвлөгөө боловсруулах



4 АЛХАМ: ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭ


11 шат: Зөвлөгөө өгөх,
үйлчилгээний зорилтонд хүрэх

12 шат: үйлчлүүлэгчдийн сэтгэл
ханамжийг судлах



Хувь хүний хэрэгцээг тодорхойлох үйл явц

1. Ажил мэргэжлийн талаар шийдвэр гаргах
2. Чадавхаа дээшлүүлэх
3. Ажил хайх
4. Хөдөлмөр эрхлэлийн тогтвортой байдал




1-р үе шат
хэрэгцээг
тодорхойлох

- Нээлттэй ярилцлага
- Мэдээлэл цуглуулах
- Хэрэгцээг тодорхойлох
- Шалгуурт тэнцсэн эсэхийг үзэх
- Хувилбар болон холбогдох арга хэмжээг хянах




1. Бусад үйлчилгээ эсвэл байгууллагад тохирч болох зүйлийг санал болгох
2. Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах



2-р үе шат: Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

- Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
- Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд үйлчлүүлэгчийн оролцоог хангах



3-р үе шат:
Бичиг баримт бөглөх

- Анкет
- CV
- Өргөдөл
- Намтар




Үйлчлүүлэгчийн үйл ажиллагааны төлөвлөгөө

1. Ажил мэргэжлийн шийдвэр гаргалт нь ажил мэргэжлийн сонголт хийхтэй эсвэл ажлын сонголтын дагуу нэг ба түүнээс дээш сонголт хийх бололцоотой байхтай холбоотой чадвар ба мэдлэгийг агуулдаг.

2. Чадвар дээшлүүлэхэд ажлын байранд тавигдах ерөнхий шаардлага болон тухайн ажил мэргэжлийн онцлогт тохирсон чадвар орно.

3. Ажил хайх чадвар нь ажлыг үр дүнтэй хайх чадвар эсвэл ажил хайлтын бие даасан байдлыг хэлнэ.

4. Ажлын байраа тогтвортой хадгалах чадварыг хувь хүний ажлын байраа тогтвортой хадгалах эрмэлзэлтэй холбох



ХАРИЛЦААНЫ ДҮРЭМ

Хэлсэн гэдэг нь сонссон гэсэн үг биш

Сонссон гэдэг нь ойлгосон гэсэн үг биш

Ойлгосон гэдэг нь хүлээн зөвшөөрлөө гэсэн үг биш

Зөвшөөрлөө гэдэг нь хийнэ гэсэн үг биш

Хийнэ гэдэг нь тогтмол хийнэ гэсэн үг биш





Funded by the
European Union



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага



International
Labour
Organization



UN
DP

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХИЙН АЖИЛД ЗУУЧЛАЛЫН МЭДЛЭГ, ЧАДВАР, ИНТЕГРАЦЧИЛАХ СТРАТЕГИ, ОНОЛ АРГА ЗҮЙ

АЖИЛ ХАЙГЧ, АЖИЛГҮЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БЭЛЭН
БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ, ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙН СУРГАЛТ

Олон улсын хүүхдийн “Найрамдал” зуслан - 2022.04.18-19




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БОЛ ХӨГЖЛИЙН ХҮЧ



“Нийгмийн халамжаас хөдөлмөр рүү үе шаттайгаар шилжинэ”

~ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд А.Ариунзаяа



- Монгол гэдэг том айлын
- Хөдөлмөрийн насны хүн амын тоо буурах хандлагатай бол,
- Ажиллах хүч 2018 оноос хойш тасралтгүй буурсан байна.



Үндэсний
статистикийн хороо,
Хөдөлмөрийн
судалгааны институт,

150
АЖИЛТАН

ХӨДӨЛМӨРИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД
ХҮРЧ АЖИЛЛАХ ТАЛБАР

87 700+
ИРГЭН

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ



Бидэнд ямар бэрхшээл байна вэ?

Бид хэн бэ?

Бид хаана байна вэ?

Бид хаашаа явж байна вэ?

Бидний замд ямар юу юу саад болж байна вэ?

Дотроосоо шийдэл дэвшүүлж, өөрчлөх шаардлага байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ САЛБАРЫН БЭРХШЭЭЛ

- Ажлын ачаалал ихтэй байдаг,
- Тайлан боловсруулдаг,
- Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлмээр байдаг,
- Статистик гаргадаг,
- Зээлийн эргэн төлөлтийн араас явдаг,
- Гэнэтийн ажил маш их гардаг,
- Нэг хүнд оногдох үйлчлүүлэгч олон,
- Өөрийгөө хөгжүүлэх, өсөн дэвжих боломж хомс,




АЖИЛД ЗУУЧЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

- **ажилд зуучлах** гэж ажил хайж байгаа иргэнд хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварт нь тохирсон ажил олоход, ажил олгогчид эрэлт хэрэгцээнд нь нийцсэн ажилтан олоход туслалцаа үзүүлэх үйлчилгээг (*Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 3.1.10*).




- **ажилд зуучлах, авах (recruitment)** гэдэгт ажлын байрны талаарх мэдээллийг сурталчлах, түгээх, ажилтныг сонгон шалгаруулах, тээвэрлэх, ажилд нь оруулах, цагаач ажилтны хувьд боломжтой тохиолдолд илгээгч улс руу буцаах ажиллагааг хамааруулна. Энэ нь ажил хайгч болон хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын аль алинд хамаарна (*Олон улсын хөдөлмөрийн байгууллага*).




АЖИЛД ЗУУЧЛАЛЫН ХӨГЖИЛ

- Ажилд зуучлах шинжтэй үйл ажиллагаа 500 гаруй жилийн өмнөөс улбаатай юм байна. Германд хотын нийгмийн албад нь ажилд зуучлах үйлчилгээ эхлүүлсэн нь 1840-өөд он.
- Монгол Улсад 2003 онд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” Монгол Улсын хууль батлагдсан. Уг хуулийн 2-р бүлэгт **ажил зуучлах** нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээний нэг болохыг хуульчлан тусгажээ.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ Profiling хийх үйл явц

45-50
 МИН



ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН


I.Ерөнхий мэдээлэл
20 хэсэг

II.Боловсрол, чадварын мэдээлэл
6 хэсэг

III.Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээлэл
29 хэсэг

IV.Үнэлгээ боловсруулахад шаардлагатай мэдээлэл
6 хэсэг

V.Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө
1 хэсэг



Үнэлгээг Р.ЛЕЙКЕРТИЙН
шкалын аргачлалыг ашигласан

“ Хөдөлмөр эрхлэх ур чадварын сэтгэл зүй нийгмийн шинжид баримжаалсан загвар ”





Funded by the European Union



Food and Agriculture Organization of the United Nations

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага



International Labour Organization



UNDP

Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй

“Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл

PROFILING-ИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙН

Суурь ойлголт



Хөдөлмөр эрхлэх ур чадварын сэтгэл зүй нийгмийн шинжид баримжаалсан загвар



Ажил мэргэжил судлал, сэтгэл судлал, хөдөлмөр судлалын онолын суурь ойлголт




Р.ЛЕЙКЕРТИЙН шкалын аргачлалыг ашиглан үнэлгээг хийсэн




PROFILING-ИЙН ХЭРЭГЛЭЭ

Үйл явц



АЖИЛД ЗУУЧЛАЛ ДУНД ҮҮСДЭГ СААД

- Талууд харилцан бие биенийхээ талаар бүрэн мэдээлэл, мэдлэггүй байх,
- Аль нэг талынх нь нийлүүлэлт буюу шаардлага, нөхцөл байдал нь нөгөөгийнхтэйгөө уялдахгүй байх,
- Талуудын уян хатан байдал дутагдах,
- Эрэлт, нийлүүлэлтийн талууд хоорондоо богино хугацаанд, шууд холбогдох боломж хязгаарлагдмал буюу ихээхэн цаг хугацаа шаардагддаг байх,
- Зах зээл дээр эрэлт, нийлүүлэлтийн талууд холбогдоход бэрхшээл учруулдаг хүчин зүйлүүд,
- Зах зээл дээр холбогдох боломжтой эрэлт, нийлүүлэлтийн аль нэг тал нь нөгөөгөөсөө түргэн өөрчлөгдөх байдал г.м.



АЖИЛД ЗУУЧЛАЛЫН АЖИЛТНЫ МЭДЛЭГ



АЖИЛД ЗУУЧЛАЛЫН АЖИЛТНЫ ЧАДВАР

ЧАДВАР БА ХАНДЛАГУУД

Техник чадвар	Үйлчлүүлэгчид төвлөрсөн хандлага
Санаачилга гаргах чадвар ба хандлага	Үр дүнг баримжаалсан хандлага
Төлөвлөлт ба менежментийн чадвар	Байгууллага доторх удирдлагын харилцааны чадвар
Ажил горилогч болон ажил олгогчид зөвлөгөө өгөх чадвар	Ойлгомжтой бөгөөд анхаарал татах харилцааны чадвар
Шинжлэн дүгнэх ба тайлбарлах чадвар	Бие хүн хоорондын харилцааны чадвар
Үр ашигтай уулзалт-дэмжлэг үзүүлэх чадвар	

МЭДЛЭГ

Ажилтан шалгаруулж авах, элсүүлэх хэлбэрүүд	Хөдөлмөрийн зах зээлийн хандлага ба шинж чанар
Ажил эрхлэлт дэмжих төрийн болон хувийн хөтөлбөрүүд	Суурь цалингийн аргачлал
Чадавх хөгжүүлэх сураглтын хөтөлбөрүүдийн агуулга	Ажилд орох ярилцлагын арга техникүүд
Мэдээллийн сангийн менежментийн хэрэглээ	Бизнесийн салбарт ажилтан шалгаруулж авах үйл явц
Мэдээллийн сан болон бусад софтверийн мэдээллийн технологийн мэдлэг	Ажил эрхэлж буй хүмүүсийн чадвар болон шинж чанарыг сайн ойлгох (нийгэм, боловсрол, эдийн засаг, соёл)
Ажил олгогчдын зүгээс хамгийн чухалчилж буй ажлын байрны шаардлагууд	Хөдөлмөр болон нийгмийн хамгааллын хуулиуд

Clara Lucia Perez, Ажилд зуучлалын мэргэжилтний нийтлэг мэдлэг, чадварыг тодорхойлжээ.



АЖИЛД ЗУУЧЛАЛЫН АЖИЛТНЫ ДАДАЛ

Өөрийн сангийн агуулгыг тасралтгүй хөгжүүлэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг ашиглах.

Боловсрол, ажил мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн ахисан түвшний боловсролын институцүүдэд тогтмол зочлох.

Нийтэд хандсан тогтмол хэвлэлийн эх сурвалжууд, лекц арга хэмжэнэд хамрагдах.

Тулгамдаж буй асуудлын талаарх мэдээлэл, шинэ мэдээллүүдийн талаар хамтран ажиллагсадтайгаа тогтмол яриа хэлэлцүүлэг өрнүүлэх.

Боловсрол, үйлдвэрлэл, захиргааны байгууллагуудад зочлон ажил мэргэжлийн бодит байдалтай газар дээр нь тогтмол танилцаж байх.

Мэргэжил сонгогч, мэдээллийн бусад хэрэглэгчдэд зориулан нийлүүлж буй мэдээллийн чанарт ямагт шүүмжлэлт байр сууринаас хандах.

Худалдаа үйлдвэрийн танхим, мэргэжлийн холбоод болон бусад эдийн засгийн хөгжлийг дэмждэг байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцож байх.



ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ РҮҮ ИНТЕГРАЦЧИЛАХ НЬ

ЗОРИЛТУУД

1. Хувийн хэвшил, байгууллагуудын хүний нөөцийг шуурхай бүрдүүлэх.
2. Хүмүүсийн хөдөлмөр эрхлэх чадварыг сайжруулах.
3. Ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх, тогтворжуулах.
4. Хөдөлмөр эрхлэлтийн бүтцэд нөлөөлөх хийгээд зорилтот бүлгүүдийг дэмжих.
5. Нийгэм болон улс төрийн зорилго.

ТӨРЛҮҮД

- Ажил хайгч болон ажил олгогчийг дэмжих стратеги,
- Хувиараа хөдөлмөр эрхлэхийг нь дэмжих стратеги,
- Зорилтот бүлгүүд (ерөнхий ба тусгай)-ийг дэмжих стратеги,



ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ РҮҮ ИНТЕГРАЦЧИЛАХ НЬ

АСУУЛТ ҮЗҮҮЛЭЛТ

Зорилтот ажил мэргэжилд зуучлагдах боломж

Мэргэжлийн тохирц байдал

Эзэмшсэн боловсрол ба хөдөлмөрийн чадвар

ШААРДЛАГУУД

Хөдөлмөрийн зах зээл, ажлын байрны шаардлагууд

Мэргэжилд тавигдах тусгай шаардлагууд ба боломжит сэтгэл ханамж

Мэргэжлээс гадуурх болоод амьдралын нөхцөлд тавигдах шаардлагууд

АЖИЛ ХАЙГЧИЙН ШИНЖ ЧАНАР

Нийгэм хүн ам зүйн шинж чанар
 Боловсрол болон ажил мэргэжлийн намтрын шинж чанар

Танин мэдэхүйн болон оюун ухааны чадвар
 Эрүүл мэнд

Зан үйл болон хувь хүний шинж чанар
 Амьдралын нөхцөл байдал

Bohrke-Petrovic-ийн НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ-ний загвар.





Funded by the
European Union



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага



International
Labour
Organization



АЖИЛ ХАЙГЧИЙГ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТЭД НИЙЦҮҮЛЭХ НЬ

“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ



АЖИЛ ХӨДӨЛМӨР НЬ



ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХ СОНГОЛТ



Албан
байгууллагад
зуучлах

- Төрийн
- Орон нутгийн
- Хувийн



Хувиараа
бизнес
эрхлэх

- Санхүүгийн дэмжлэг-зээл
- Түрээсийн хөнгөлөлт
- Аж ахуй эрхлэлтийг дэмжих сургалт
- Борлуулалтын дэмжлэг



АЛБАН БАЙГУУЛЛАГАД ЗУУЧЛАХ, АЖИЛ ОЛГОГЧИЙН ТАВЬДАГ НИЙТЛЭГ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Боловсрол

Ажлын
туршлага

Мэргэжил

Зөөлөн ур
чадвар

Мэргэшил



АЖИЛ ХАЙГЧ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХҮЧИН ЗҮЙЛС

ХҮСЭЛ, СЭДЭЛ 01

- Хүсч буй ажлын байр
- Ажил олохын тулд хийсэн үйлдэл
- Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй эсэх



02 ТЕХНИКИЙН УР ЧАДВАР

- Ажлын туршлага
- Боловсрол
- Мэргэжил
- Мэргэшил



ЗӨӨЛӨН УР ЧАДВАР 03

- Харилцааны чадвар
- Суралцах чадвар
- Багаар ажиллах чадвар
- Хариуцлага хүлээх чадвар
- Өөрийгөө үнэлэх чадвар



04 СОНИРХОЛ, ЧАДАМЖ


- Чадавх
- Сонирхож буй ажил



СУДАЛГААНД ХАМРАГДСАН ААН-ҮҮД ХАМРАГДАЛТЫН ТОО, ХОРОО ТУС БҮРЭЭР

Зорилтот 4 хорооны нийт 274 ААН-ээс 85 буюу 21 хувиас судалгаа авсан.

■ Судалгаа авсан ААН




Төслийн зорилтот 4 хороонд үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн хувьд: 40-50%-ийг 1-3 ажилтантай гэр бүлийн гишүүдийн хамтарсан хүнсний дэлгүүрүүд, 10-15 хувийг мөн 1-3 ажилтантай өрхийн гишүүдийн хамтарсан үсчин, халуун ус, оёдол, гутал засвар зэрэг газрууд багтаж байна.

ААН-үүдийг судалгаанд хамруулахдаа хүнсний дэлгүүр зэрэг 1,3 ажилтантай байгууллагуудаас төлөөлөл болгон сонгож харин 5-аас дээш ажилтантай харьцангуй олон ажлын байр бий болгож буй газруудыг бүрэн хамруулж, ажилгүй иргэдийг зуучлахыг зорьж ажилласан.



ААН-ҮҮДЭД ХҮНИЙ НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ТУЛГАМДАЖ БУЙ ХҮНДРЭЛ, АЖИЛ ОЛГОГЧ НАРЫН ЗҮГЭЭС ТАВЬЖ БУЙ ШААРДЛАГА




ААН-үүдтэй ярилцлагын аргаар хийсэн судалгааны үр дүнгээс авч үзэхэд хүний нөөц бүрдүүлэлттэй холбоотой тулгамдаж буй хамгийн том сорилт (чэллэнж) бол ажлын зөөлөн ур чадвар (soft skills) болох нь харагдсан. Энэ нь цаашид төслийн үргэлжлэх шатны үйл ажиллагаанд ажлын байрны зуучлал хийгдэж буй иргэдэд техникийн ур чадварт анхаарахын зэрэгцээ зөөлөн ур чадвар эзэмшүүлэх тал дээр анхаарах. Мөн үүний зэрэгцээ аж ахуйн нэгжүүдэд хүний нөөцийн удирдлага тал дээр илүү анхаарч үзэх хэрэгтэйг тодорхойлж байна.




ААН, БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ОДООГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Бүтээгдэхүүний борлуулалт, зах зээлийн эрэлт




Ажиллах хүчний хомсдолтой эсэх




ХХҮ-ний хэлтэс ААН хоорондын хамтын ажиллагаа



Ажилтнуудаа хөгжүүлэх чиглэлээр



Ойрын 5 жилд үйл ажиллагаагаа өргөжүүлэх эсэх



■ Борлуулалт бага

■ Дунд зэрэг, боломжийн

■ Хангалттай сайн, эрэлт их

■ Ажиллах хүчний хомсдолтой

■ Одоогоор ажиллах хүчний хомсдолгүй

■ Хамтран ажилладаг

■ Хамтран ажилладаггүй

■ Сургалт, арга хэмжээ зохион байгуулдаг

■ Зохион байгуулдаггүй


■ Хүрэх зорилт

■ Үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй

■ Үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөгүй



АЛБАН БАЙГУУЛЛАГАД ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ





Food and Agriculture
Organization of the
United Nations



International
Labour
Organization



UN
DP

Funded by the
European Union

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага

Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй

“Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл

ХУВИАРАА БИЗНЕС ЭРХЛЭХ



АЖИЛ МЭРГЭЖИЛ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
NATIONAL INSTITUTE OF CAREER STUDIES

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА



**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ
(ПРОФАЙЛИНГИЙН)
НЭГДСЭН МАЯГТЫН АГУУЛГЫН НЭРШИЛ-ОЙЛГОЛТ, ЗААВАРЧИЛГАА**

Бүртгэлийн дугаар: Бүртгэлийн дугаарыг программ автоматаар тооцоолж гаргана. Жич: “E-job” нэгдсэн програм хэрэглээнд нэвтрэх хүртэлх хугацаанд зөвлөх мэргэжилтэн бүртгэлийн түр дугаар оноож өгнө. Бүртгэлийн дугаар нь 15 оронтой тооноос бүрдэнэ. Үүнд, эхний 2 оронтой тоо - аймаг, нийслэлийн код; дараагийн 2 оронтой тоо - сум, дүүргийн код; дараагийн 2 оронтой тоо - баг, хорооны код болно. Харин дараагийн 6 оронтой тоо нь он, сар, өдрийн код болно (жишээлбэл, 2022 оны дөрөвдүгээр сарын 6-ны өдрийг 22-04-06 гэж кодолж бичнэ). Дараа нь, зөвлөх мэргэжилтний код нь 1 оронтой бүхэл тоо (1-9 хүртэлх) байна. Үүний араас хөдөлмөр эрхлэлтийн албанд хандаж байгаа үйлчлүүлэгчийн код 2 оронтой (01-99 хүртэлх) бүхэл тоо байна.

Кодын тайлбар:

1	2	3	4	5	6	2	2	0	4	0	6	1	0	9
Аймаг, нийслэлийн код	Сум, дүүргийн код	Баг, хорооны код	Оны сүүлийн 2 орон код	Сарын 2 орон код	Өдрийн 2 орон код	Зөвлөхийн код	Аймаг, нийслэлийн код							

I. Үйлчлүүлэгчийн ерөнхий мэдээлэл

I.1 Ажил хайгчийн төлөв байдал:

Ажилгүй иргэн гэж ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ

Ажилтай ч нэмэлтээр эсвэл ажлаа солихоор ажил хайж буй иргэн гэж: ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор 2 дахь ажил хайж байгаа иргэн, эсвэл одоогийн ажлаа солихыг хүсч байгаа иргэн үүнд хамаарна.

Хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй буюу одоо эрхэлж байгаа иргэн гэж: дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлсэн, бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрээ хараат бусаар бие даан гаргадаг иргэнийг хэлнэ.

I.2 Бүртгэлтэй эсэх: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем (LMIS)-д бүртгэлтэй эсэхийг шалгах. Бүртгэлгүй тохиолдолд шинээр бүртгэл үүсгэнэ.

I.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдаж байсан эсэх: Хариултын зохих кодыг дугуйлж тэмдэглэнэ.

I.4 Хамрагдаж байсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний мэдээлэл: Өмнө нь буюу хамрагдаж байсан хөтөлбөр, арга хэмжээний мэдээлэл, хамрагдсан оныг нөхөж бичнэ.

I.5 Регистрийн дугаар: Тухайн иргэний регистрийн дугаарыг бичнэ.

I.6 Нэрийн хэсэг: Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрийг бичнэ.

I.7 Нас: Тухайн иргэний насыг бичнэ

I.8 Хүйс: Хариултын зохих кодыг дугуйлж тэмдэглэнэ.

I.9 Хаяг 1: Иргэний үнэмлэх дээр бичигдсэн оршин суугаа хаягийг бичнэ. Иргэний аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж хорооллын нэр, дугаар, байшин, байр, хашаа, хаалганы дугаарыг бичнэ.

I.10 Хаяг 2: Иргэний үнэмлэх дээр бичигдсэн хаягаас өөр газар одоогоор түр оршин сууж байгаа бол бичнэ. Одоогоор түр оршин сууж байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж хорооллын нэр, дугаар, байшин, байр, хашаа, хаалганы дугаарыг тодорхой бичнэ.

I.11 Холбоо барих мэдээлэл: Иргэний гар утас, яаралтай үед холбоо барих хүний утас, цахим шуудан, фейсбүүк хаягийг тодорхой бичнэ.

I.12 Өрхийн ам бүл: Иргэн нэг гэрт хамт амьдарч байгаа өрхийн гишүүдийн тоог бичнэ.

I.13 Нэг өрхөд хамт амьдарч байгаа хүмүүс: Өрхийн гишүүдийг нэг бүрчлэн, тухайн иргэний юу болохыг тодорхойлж бичнэ (Эхнэр, нөхөр, хүүхэд, аав, ээж, ах, дүү, г.м)

I.14 Хүүхдийн тоо: Энд 0-18 хүртэлх насны хүүхдийн тоог бичиж тохирох хэсэгт оруулна.

I.15 Нийгмийн халамжид хамрагддаг эсэх: Хариултын хувилбарын кодыг дугуйлна.

I.16 Нийгмийн халамжид хамрагддаг бол ямар халамжуудыг авдаг вэ: Нийгмийн халамжийн жагсаалтын 72 төрлөөс хамрагддаг халамжуудаа сонгож, кодыг дугуйлна.

I.17 Өрхийн орлогын эх үүсвэрүүд: Харгалзах кодыг дугуйлна. Өрхийн орлогын эх үүсвэрт Цалин хөлс; Халамж (тэтгэвэр, тэтгэмж); Албан бус хөдөлмөр эрхлэлтийн орлогыг тус тус хамруулж ойлгоно.

I.18 Өрхийн сарын дундаж орлогын хэмжээ: Иргэний хэлсэн сарын дундаж орлогын хэмжээг бичнэ.

I.19 Тухайн өрх зээлтэй эсэх: Хариултын хувилбарын кодыг дугуйлна.

I.20 Хэрэв зээлтэй бол сар бүр эргүүлэн төлж байгаа зээлийн хэмжээ: Өрхийн сар бүр эргүүлэн төлдөг зээлийн хэмжээг бичнэ.

II. БОЛОВСРОЛ, ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ

II.1 Боловсролын түвшин: Боловсролын тогтолцооны албан ёсны түвшний хувилбаруудаас харгалзах кодыг дугуйлна. Үүнд:

Бүрэн дунд хүртэлх боловсролын түвшинг тодорхойлохдоо дараах хүснэгтийг ашиглана.

Он	Боловсролгүй	Бага	Суурь (Бүрэн бус дунд)	Бүрэн дунд
1975 хүртэлх онуудад	4-р ангийг төгсөөгүй	4-р анги төгссөн	7-р анги төгссөн	10-р анги төгссөн
1975-1996 онуудад	3-р ангийг төгсөөгүй	3-р анги төгссөн	8-р анги төгссөн	10-р анги төгссөн
1997-2004 онуудад	4-р ангийг	4-р анги	8-р анги	10-р анги

	төгсөөгүй	төгссөн	төгссөн	төгссөн
2005 онд	5-р ангийг төгсөөгүй	5-р анги төгссөн	9-р анги төгссөн	10-р анги төгссөн
2006-2014 онуудад	5-р ангийг төгсөөгүй	5-р анги төгссөн	9-р анги төгссөн	11-р анги төгссөн
2015 ба түүнээс хойш онуудад	5-р ангийг төгсөөгүй	5-р анги төгссөн	9-р анги төгссөн	12-р анги төгссөн

Техникийн болон мэргэжлийн боловсрол: Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, эсвэл богино болон түр хугацааны сургалт (курс дамжаа)-нд суралцаж мэргэжлийн үнэмлэх (сертификат) авсан хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

Тусгай мэргэжлийн дунд боловсрол: Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөнийг гэрчлэх үнэмлэх дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

Дээд боловсрол: /дипломын дээд, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/. Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ.

II.2 Эзэмшсэн мэргэжил: Эзэмшсэн мэргэжлийг үйлчлүүлэгчийн мэргэжлийн сургууль, сургалт (курс, дамжаа) төгссөнийг гэрчлэх диплом, гэрчилгээ, сертификат дээр бичигдсэн мэргэжлийн нэрээр нь бичнэ. Сургуулийн нэр, суралцсан хугацаа, төгссөн он зэргийг холбогдох багануудад бичнэ.

II.3 Хөгжлийн бусад сургалт /урлаг, соёл, спортын болон бусад хөгжүүлэх сургалт/-д хамрагдсан байдал: Иргэн өөрийгөө хөгжүүлэх зорилгоор хамрагдсан хувь хүний хөгжилд чиглэсэн богино хугацааны танхимын болон онлайн сургалтуудыг хэлнэ.

II.4 Амьдрал, үйл ажиллагааны явцад сурч эзэмшсэн чадварууд: Энэ асуултыг мэргэжил эзэмшээгүй, албан ёсны сургалтад хамрагдаагүй иргэний хөдөлмөр эрхлэх боломж чадварыг тодруулах зорилгоор асууна. Иргэн албан бус сургалтаар юм уу, амьдрал, үйл ажиллагааныхаа явцад сурч эзэмшсэн чадваруудыг энд хамааруулна. Жишээ нь, оёдол хатгамал, зураг зурах, хоол хийх, жимс ногоо тарих, барилгын засал, мужааны ажил, цэцэг тарьж ургуулах, мал амьтан арчлах г.м. Харгалзах баганад эзэмшсэн чадваруудыг тэмдэглэж, хэзээ буюу ойролцоогоор хэдэн жилийн өмнө суралцсаныг; хаана буюу ямар орчин нөхцөлд суралцаж эзэмшсэнийг; хэрхэн буюу хэнээс, яаж суралцсаныг тус тус тэмдэглэнэ.

II.5 Гадаад хэлний мэдлэг: Сурч эзэмшсэн гадаад хэлний нэрийг өгөгдсөн хүснэгтэд бичиж, тохирох түвшинг тэмдэглэнэ. Тухайн хэлний мэдлэгийн түвшинг албан ёсоор баталгаажуулдаг байгууллагын шалгалтад тэнцсэн эсвэл үнэлүүлснийг нотлох бичиг баримт байгаа эсэхийг асууж, хариултын хувилбарыг тэмдэглэнэ.

II.6 Компьютер хэрэглэх чадвар: Эзэмшсэн программын нэрийг бичиж тохирох түвшинд харгалзах тэмдгийг тавина.

III. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

III.1 Хөдөлмөр эрхэлсэн туршлага: Иргэний өмнө нь ажилласан байдлыг бичнэ. Ингэхдээ урьд өмнө эрхэлж байсан ажлуудаас хамгийн урт хугацаагаар ажилласан 3 хүртэлх ажлын мэдээллийг харгалзах багануудад бичнэ.

III.2 Хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэн урьд нь хувиараа хөдөлмөр (бизнес) эрхэлж байсан эсэх: Хариултын хувилбарын кодыг дугуйлна.

III.3 Хувиараа хөдөлмөр эрхэлж байсан туршлагын мэдээлэл: (гараар бичиж оруулах) Тухайн иргэний ямар үйл ажиллагаа эрхэлж байсан, байршил, хугацаа, хувиараа хөдөлмөр эрхлэлтээ зогсоосон шалтгааныг бичнэ

III.4 Ажиллаж байгаа ч өөр ажилд орох хүсэлтэй иргэний одоо эрхэлж байгаа ажил: Тухайн иргэний ажиллахыг сонирхож байгаа ажлын байрны эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлийг бичнэ. ЭЗБТҮАСА-ын дагуу 4 оронтой кодыг тэмдэглэнэ.

III.5 Хайж байгаа ажлын нэр: Тухайн иргэний хайж буй ажлын нэрийг бичнэ. Ажлын нэрийг Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ҮАМАТ-08)-ын дагуу 4 оронтой кодоор тэмдэглэж бичнэ.

III.6 Ажил хайж эхэлснээс хойших хугацаа: Хугацааг нөхөж бичнэ

III.7 Ажил хайж буй аргууд: Хариултын тохирох хувилбарыг тэмдэглэнэ. Хэд хэдэн сонголттой байж болно.

III.8 Ажилд орохын тулд анкетаа ажил олгогчдод хэдэн удаа өгсөн бэ: Хариултын тохирох хувилбарыг тэмдэглэнэ.

III.9 Ажилд орохын тулд ярилцлагад хэдэн удаа орсон бэ: Хариултын тохирох хувилбарыг тэмдэглэнэ.

III.10 Хувиараа хөдөлмөр эрхлэхийг хүсч байгаа үйл ажиллагааны төрөл: Тухайн иргэний хувиараа хөдөлмөр эрхлэхээр хүсч байгаа үйл ажиллагааны төрлийг бичиж оруулна.

III.11 Хувиараа эрхлэх хөдөлмөр (бизнес) нь хамтрагчтай эсэх: Хариултын тохирох хувилбарыг тэмдэглэнэ.

III.12 Хувиараа эрхлэх хөдөлмөрөө эхлүүлэхэд тулгарч буй бэрхшээл: Хариултын тохирох хувилбарыг тэмдэглэж. Бусад тохиолдолд нөхөж бичнэ.

III.13 Ажилд орох боломжтой хугацаа: Тухайн иргэн өнөөдрөөс эхлэн тооцвол хэд хоногийн дотор ажилд орох боломжтой байгааг хоногоор тоолж бичнэ. “0 хоног” гэдэг нь “Одоо шууд ажиллахад бэлэн” гэдэг утгыг илэрхийлнэ.

III.14 Үйлдлийн чадамж дахь хүндрэлийг тодорхойлох өөрийн үнэлгээ: Зөвлөх мэргэжилтэн иргэнд энгийн 6 асуулт тавихыг сануулна. Эдгээр асуултыг иргэн өөрийнхөө хувьд 4 түвшнээр үнэлж, хариулахыг хүснэ. Ингээд 4 түвшнийг уншиж өгч, танилцуулсны дараа асуулт тус бүрийг уншиж өгнө. Харгалзах асуулт тус бүрд тохирох хариултыг хэлсний дагуу дугуйлна.

- **Танд юм харахад хүндрэлтэй байдаг уу?** Харааны бэрхшээлтэй буюу харааны шил, контакт линз зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд харахад хүндрэлтэй эсэхийг илрүүлэх зорилготой. Тухайн иргэнээс асууж тодруулсны эцэст хариултын тохирох хувилбарыг тэмдэглэнэ.
- **Танд юм сонсоход хүндрэлтэй байдаг уу?** Энэ асуултын зорилго нь сонсголын бэрхшээлтэй, сонсголын аппарат зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд сонсоход хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. **Сонсгол** нь эргэн тойрны дуу чимээг сонсох, мөн аюултай нөхцөл байдлаас өөрийгөө хамгаалах баримжааг олгож байдаг. Сонсох бэрхшээлд чимээ ихтэй орчин эсвэл нам гүм орчинд янз бүрийн дуу чимээг ялгаж сонсоход нэг эсвэл 2 чихээрээ сонсоход хүндрэл тулгарч байгааг ойлгоно. Тухайн хүн сонсголын аппарат зүүдэг бол **Та сонсголын аппарат зүүсэн ч юм сонсоход хүндрэлтэй байдаг уу?** гэж асуух хэрэгтэй.

- **Танд алхах болон шатаар өгсөх/дээшээ авирахад хүндрэлтэй байдаг уу?** **Алхахдаа** ямар нэгэн хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. **Алхах** гэдэг нь хөлийг нэг цэгээс нөгөөд зөөх хөдөлгөөн юм. Ямар нэгэн дэмжлэг болох төхөөрөмж (тэргэнцэр, таяг, алхуулагч гэх мэт) эсвэл хэн нэгний туслалцаагүйгээр алхаж чадаж байвал алхаж чаддаг гэж үзнэ. Богино зайд (ойролцоогоор 100 метр) эсвэл хол зайд (ойролцоогоор 500 метр) алхахад тулгарч байгаа хүндрэлийг оруулсан. Замдаа амрахгүй зогсохгүйгээр зорих газартаа алхаад очиход бэрхшээлтэй байгаа тохиолдлыг оруулна. Алхахад хүндрэлтэй гэдэгт алхсанаас эсвэл шатаар дээш, доош алхсанаас шалтгаалж бие сулрах, тэнцвэр алдах, эсвэл бусад тулгуур эрхтэн тогтолцооны бус хүндрэл тохиолдож байгааг оруулна.
- **Танд аливаа зүйлийг санах, анхаарлаа төвлөрүүлэхэд хүндрэлтэй байдаг уу?** **Эргэн санах** гэж нь өнгөрсөн үйл явдлыг эргэж санахыг ойлгоно. Аливаа зүйлийг эргэн санах нь цээжлэх, ой тогтоолттой ижил биш. Анхаарлаа төвлөрүүлэх гэдэг нь аливаа зүйлийг хийхэд оюуны чадамжаа ашиглах явдал юм. Тухайлбал, ном унших, тоо бодох, аливаа зүйлийг сурахад хүн оюуны чадамжаа ашиглаж байдаг. Аливаа зүйлийг гүйцэд хийж гүйцэтгэхэд л зөвхөн голчлон анхаарах юм. Зам харгүй олох, аливаа асуудалд анхаарлаа хандуулж чадахгүй байх, хаана байгаагаа эсвэл он сараа мартаж зэргийг бэрхшээлтэй гэж үзнэ. Мөн хэн нэгний хэлсэн ярьсныг санахгүй байх, будилах, ихэнх зүйлсээс айх зэргийг хүндрэлтэйд тооцно. Тэмдэглэл: Ажлын ачаалал, стресс бухимдал, эмийн нөлөөний улмаас үүссэн санах, анхаарлаа төвлөрүүлэхтэй холбоотой хүндрэлийг **ХҮНДРЭЛТЭЙ ГЭЖ ҮЗЭХГҮЙ.**
- **Танд бие даан усанд орох, хувцсаа өмсөх зэргээр өөрийгөө арчлахад хүндрэлтэй байдаг уу?** Энэ асуулт нь бие даан өөрийгөө халамжлах, анхаарахад хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. **Усанд орох** гэдэг нь биеэ угаах (савандаж угаах)-ыг ойлгоно. Саван, шампунь, бие угаагч, ус зэрэг шаардлагатай зүйлийг хэрэглэн үсээ, хөлөө угааж чаддаг бол оруулна. **Хувцаслах** гэдэгт өмд, цамцаа өмсөх, гутлаа өөрөө өмсөхийг ойлгоно. Мөн хувцасны шүүгээнээс хувцсаа авах, товчоо товчлох, үдээс үдэх, цахилгаан татах гэх зэргийг оруулна. Угаах, хувцаслах өдөр тутамдаа хийгддэг үйл ажиллагаа юм.
- **Танд бусадтай ярилцахад ямар нэгэн хүндрэл гардаг уу?** Энэ хэсэг нь ярих, сонсох, бусдыг ойлгох, бусдад өөрийгөө ойлгуулахад ямар нэг хүндрэлтэй байдаг хүмүүсийг илрүүлэх зорилготой. **Ярилцах** гэдэг нь хүмүүсийг аливаа нэг хэлээр бусадтай мэдээлэл болон өөрийн үзэл санаагаа солилцох үйл явц юм. Харилцааны хүндрэл нь олон зүйлээс шалтгаалж байдаг. Тухайлбал, сонсгол эсвэл хэл ярианы бэрхшээлээс шалтгаалж бусадтай харилцах чадахгүй байх, эсвэл дуу чимээг хүлээн авах чадвартай холбоотой буюу авиа ялгаж сонсдоггүй байж болно. Мэдээлэл солилцохдоо дохио зангаа хэрэглэдэг (дохионы хэл орно), бичгээр эсвэл дуу авиа ашигладаг бол харилцааны бэрхшээлтэй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, бусдад өөрийгөө ойлгуулахдаа эсвэл бусдын яриаг ойлгохдоо харилцааны өөр арга хэрэглэж байгаа тохиолдлыг ойлгоно.

III.15 Хөдөлмөрийн чадварын байдал: Хариултын тохирох хувилбарыг дугуйлна. Хэд хэдэн сонголт байж болно.

III.16 Хөдөлмөрийн бүрэн чадвартай биш бол ажил олгогчоос ажлын байрны нэмэлт тохируулга шаардлагатай эсэх: Хариултын харгалзах хувилбарыг дугуйлна.

III.17 Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой гэр бүлээс хамаарах саад: Хариултын тохирох хувилбарыг дугуйлна. Хэд хэдэн сонголт байж болно.

III.18 Ажиллахыг сонирхож байгаа салбар: Тухайн иргэний ажиллахыг сонирхож байгаа ажлын байрны эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлийг бичнэ. ЭЗБҮАСА-ын дагуу 4 оронтой кодыг тэмдэглэнэ.

III.19 Хайж буй ажлын байр болон хувиараа эрхлэх аж ахуйн байршил: Ажлын байрны хүсэж буй байршлын сонголтыг хариултын хувилбарт тэмдэглэнэ.

III.20 Ажлын байрны төрөл: Хариултын тохирох хувилбарын арын тоог тэмдэглэнэ.

Ажлын байр гэж цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэгцээнд зориулан хийж гүйцэтгэх ажил, үүрэг, албан тушаалыг хэлнэ. Үүнд:

- **Байнгын ажлын байр** гэж ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүй ажил үүрэг, албан тушаалыг ойлгоно. Эдгээр нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажил үүрэг, албан тушаал орно.
- **Түр ажлын байр** гэж хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3 ба түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай ажил үүрэг, албан тушаалыг ойлгоно. Эдгээр ажлын байранд ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.
- **Тохиолдлын ажлын байр** гэж ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай ажил үүрэг, албан тушаалыг тус тус ойлгоно.

III.21 Ажил хийх боломжтой цаг: Хариултын тохирох хувилбарын арын тоог тэмдэглэнэ. Хэд хэдэн сонголттой байж болно.

III.22 Хүсч байгаа цалингийн хэмжээ: Хүсч байгаа цалингийн хэмжээнд тохирох кодыг сонгоно. 1.5 саяас дээших хэмжээний цалинг гараар бичиж оруулна

III.23 Гадаад улсад оршин сууж байгаад эх орондоо ирсэн эсэх: Хариултын тохирох хувилбарыг тэмдэглэнэ.

III.24 Эх орондоо эргэн ирсэн огноо: Эх орондоо эргэж ирсэн он, сарыг бичнэ.

III.25 Гадаад улсад оршин суусан хугацааг сараар тооцож бичих: Тухайн улсад оршин суусан нийт хугацааг жил, сараар тооцож бичнэ.

III.26 Гадаад улсад амьдарч байхдаа хамгийн удаан хугацаагаар эрхэлж байсан ажил: Эрхэлж байсан ажил, гүйцэтгэж байсан үндсэн үүргүүд болон тухайн ажилдаа хэдэн сар ажилласныг бичнэ.

III.27 Зорилтот бүлгийн иргэн: Тохирох хувилбарыг тэмдэглэнэ.

“Ажил олоход хүндрэлтэй иргэн” гэж хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-д заасан иргэн, хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг;

- **Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүн:** гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран

баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг;

- **Хөдөлмөрийн насанд хүрч асрамжийн газраас гарсан иргэн:** 18 нас хүртэл асрамжийн газар өсч хүмүүжээд тус асрамжийн газраас гарсан хүнийг
- **6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн:** Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй, 6 сараас дээш хугацаагаар ажил идэвхтэй хайж байгаа боловч ажил олж чадахгүй байгаа иргэнийг хэлнэ.
- **Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд:** 15-аас 18 хүртэлх насны . ЕБС-д сурч байх үедээ ямар нэг шалтгаанаар сургуулиа орхисон, дахин үргэлжлүүлж суралцаагүй, сургууль завсардсан хөдөлмөрийн насны хүүхдийг хэлнэ.
- **Хөгжлийн бэрхшээлтэй иргэн:** Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үзнэ.
- **Хорих ангиас суллагдсан иргэн:** Хорих ялын хугацаа дууссан
- **Ажил хайгч гэж** ажилгүй, ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн болон хандсан иргэнийг;
